



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 41

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг 6.2.1, 6.4 дэх заалтыг 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 883,844 /найман зуун наян гурван мянга найман зуун дөчин дөрөв/ төгрөгийн балансын үнэтэй, 302,417 /гурван зуун хоёр мянга дөрвөн зуун арван долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурьдсан эд хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын  
23-ний өдрийн 11 тогтоолын хавсралт

**Орон нутгийн өмчийн газрын акталж, данснаас хасах хөрөнгийн мэдээлэл**

Үндсэн хөрөнгийн		Өртөг			Элэгдлийн дүн	Үлдэгдэл өртөг	
№	Нэр	х.н	Нэгж.Үнэ	Тоо	Нийт дүн		
1	Notebook	ш	400,000.00	1.00	400,000.00	250,000.05	149,999.95
2	Зөөврийн компьютер	ш	355,511.11	1.00	355,511.11	254,783.04	100,728.08
3	Камер	ш	128,333.40	1.00	128,333.40	76,643.58	51,689.82
<b>НИЙТ ДҮН</b>				<b>3.00</b>	<b>883,844.51/ найман зуун наян гурван мянга найман зуун дөчин дөрөв төгрөг/ тавин нэгэн мөнгө</b>	<b>581,426.67/тава н зуун наян нэгэн мянга дөрвөн зуун хорин зургаан төгрөг/ жаран долоон мөнгө</b>	<b>302,417.85 /Гурван зуун хоёр мянга дөрвөн зуун арван долоо төгрөг/ наян таван мөнгө</b>